




ЭКОСУМ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН



2020

ЕРӨНХИЙ

Энэхүү санхүүгийн тайланд 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс 12-р сарын 31-ний өдөр хүртэлх Эко сум ТББ-ын орлогын эх үүсвэр болон зардлыг нэгтгэн харуулав.

ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД


2020 оны Эко сум ТББ-ын нийт орлого 213,391,140₮. Энэ нь өмнөх оны тайлант үеийнхээс 500%-иар өссөн үзүүлэлт юм.

Орлогын дийлэнх эх үүсвэр нь хандив, тусламж, төсөл хөтөлбөрийн орлого ба гишүүдийн татварын орлого нь 230,000₮ байна.

2020 оны үндсэн санхүүжүүлэгчид нь:

- Европын Холбоо: 112,040,312₮;
- Люксембургийн Байгаль цаг уур, Тогтвортой хөгжлийн яам: 78,482,875₮;
- Номын Гүүр ТББ: 10,876,320₮;
- Хишиг-Өндөр сумын ЗДТГ: 9,860,000₮;
- Азийн сан: 1,901,633₮;

Өнгөрсөн оны тайлант үеийн үлдэгдэл болох 32,544,838₮-ийг оролцуулаад 2020 оны жилийн нийт төсөв 245,935,978₮ байна.




НИЙТ ЗАРЛАГА БОЛОН ДАНСНЫ ТЭНЦЭЛ

2020 оны нийт зардал 92,038,100₮ байна.

2020 оны 12 сарын 31-ний байдлаар байгууллагын санхүү 153,897,878₮-ний эерэг үзүүлэлттэй байна. Үүнийг 2020 оны эцэст хүлээж авсан санхүүжилтийн дийлэнх нь 2021 онд гарах зардлын урьдчилсан олговор гэдгээр тайлбарлах учиртай.

2020 онд зөвхөн хогны менежментийн төсөл хэрэгжсэн. Энэхүү төслийн зардал нь нийт зардлын 63%-ийг (57,879,417) , ерөнхий үйл ажиллагааны зардал үлдсэн 37%-ийг (34,158,682) эзэлж байна. Доор тайлбарласны дагуу ерөнхий үйл ажиллагааны зардалд үйл ажиллагааны гэхээсээ илүүтэй нөхцөл байдлаас шалтгаалсан зардлууд багтаж байна.

Ерөнхийдөө унааны зардал 11%-иар өсөж, материал, хангамжын зардал 48%-ийг эзэлж байна. Хүний нөөцийн зардал нь 38%, оффис болон харилцаа холбооны зардал 3%-ийг эзэлж байна.




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРДАЛ

Материал, хангамжын зардал нь үйл ажиллагааны зардлын голлох зардал бөгөөд 2020 оныхоос даруй 62%-иар (21,258,377₮) өссөн. Энэ зардал нь мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, оффисын зардал, сайн дурынхан болон хамтран ажиллагч байгууллагуудыг хүлээн авахад зориулсан гэр, матрасс гэх мэт сууцны зардлаас голчлон бүрдэж байна.

Унааны зардал 24%-иар өссөн ба (8,194,444₮) үйл ажиллагааны зардлын хоёрдогч томоохон зардал болсон нь харагдаж байна. Энэ зардал нь ажил үүргээ хилийн чанадад гүйцэтгэж байгаад КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хязгаарлалтын улмаас гацсан Эко сум ТББ-ын ажилчдын тусгаарлалтын зардал, нислэгийн зардал зэрэгтэй шууд холбоотой.

Оффис болон харилцаа холбооны зардалд оффисын түрээс, гар утас, интернэтийн төлбөрүүд хамаарагдах ба нийт үйл ажиллагааны зардлын 8%-ийг эзэлж байна.



ХОГНЫ МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН ЗАРДАЛ

2020 оны хогны менежментийн зардлын нийт 57%-ийг (33,121,700) хүний нөөцийн зардал буюу төслийн удирдагч, техникийн зохицуулагч, барилгын инженер нарын цалингийн зардал эзэлж байна. Тухайн төслийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн хандлагыг өөрчлөх, оролцоог нэмэгдүүлэх ажлууд болон практик үйл ажиллагаанууд (тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл болон барилгын ажил гэх мэт) хүний нөөцийн хэрэгцээ маш их учраас тус зардал ийнхүү өндөр дүнгээр гарсан байна.

Материал хангамжийн зардал нь төслийн зардлын 40%-ийг (23,255,537) эзэлж байна. Хог ангилах савны үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмж, түүхий эд зэрэг нь тус зардлыг голлож байна.

Төсөлтэй холбоотой унааны зардал нь нийт зардлын 3%-ийг (1,497,500) эзэлж байгаа бөгөөд Хишиг-Өндөр сумаас Булган аймаг болон Улаанбаатар хот руу зорчиход шаардагдах түлшний зардал үүнд багтана.

